

ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**Б. ӨЛЗИЙСҮРЭН «ЛЕНИНИЙ
СЭДЭВ, ДҮР ОРЧИН ҮЕИЙН
МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛД»
НОМЫН ТУХАЙ**

В.Э. Раднаев, Хэл шинжлэлийн
ухааны дэд эрдэмтэн

Лениний сэдэв, дүр орчин үеийн монголын уран зохиолд ялангуяа яруу найраг, дуу, 30—40-өөд оны зарим туурь болоод найруулал түүнчлэн орчин үеийн тусгайлсан туужуудад чухал байр суурь эзэлдэг.

Аугаа их октябрийн хувьсгалын шууд нөлөөгөөр 1921 онд Монгол оронд ардын хувьсгал ялан мандлаа. Гэтэл хөрөнгөтний объективизмын үзлийг баримтлагч Р. Рупен, Ч. Бауден зэрэг монгол судлаачид хөрш зэргэлдээ Зөвлөлт Орос-Байгалын чанад Эрхүүгээс Монгол оронд хувьсгалыг экспортлосон мэтээр бичиж байсан ба бичсээр ч байгаа юм. Гэлээ ч тэд 1911 оны автономит хөдөлгөөнөөс хойшхи монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үйл явдал, түүхэн баримтыг хэрэгсэхгүй байгаа болохоор одоо тэдний санаа илэрхий үндэсгүй болжээ. Монгол дахь ардын ардчилал болоод социализмын замнал нь дэлхийн пролетарийн аугаа их удирдагч В.И. Лениний үзэл санаа, алдар нэртэй гүнзгий холбоотой. Улс орны амьдралын бүхий л салбар дахь монголын ард түмний ололт амжилт, Зөвлөлт-Монгол хоёр орны ганбат найрамдлын хүчин зүйлүүд нь Лениний үйл хэрэг, Монгол оронд хэрэгжин биелж, хөгжиж буйг нотлон харуулж байна.

Зохиогч номынхоо оршил хэсэгт Лениний аугаа их хувьсгалын гавъяа, Лениний дүр Октябрийн хувьсгал хүртэлх, зөвлөлт засгийн өмнөх үеийн Оросын утга зохиол болоод М. Горький, В. Маяковский, С. Есенин, Д. Бедный нарын бүтээлд хэрхэн тусгагдаж байсныг товч тодорхой өгүүлж, XIX—XX зууны үеийн гадаадын дэвшилтэт уран зохиолын ертөнц дэх их жолоодогчийн дүрийг ерөнхийд нь нэгтгэн дүгнэжээ.

«В. И. Ленин, Октябрь, Монголд» гэсэн бүлэгт Монголын зохиолчид өөрсдийн зохиол бүтээлүүдэд Октябрийн социалист хувьсгалын амин чухал асуудлууд болон их удирдагч, суут сэтгэгчийн дүрийг хэрхэн яаж тусгасныг харуулсан байна.

Ялангуяа Д. Нацагдорж (1906—1937 он), уран зохиолыг үндэслэгчдийн нэг С. Буяннэмэх (1902—1937 он), уран зохиолын гарамгай зүтгэлтэн Ц. Дамдинсүрэн зэрэг ахмад болоод өнөөгийн алдартай зохиолчдын орчин үеийн монголын уран зохиолын сонгодог бүтээлүүд дэх улс төр уянгын харилцаанд анхаарууштай. Зохиогч, Октябрь, Ленин хэмээх салшгүй нэгдэл нь монголын хувьсгалын үйл хэргийн төлөө зүтгэгчдийн оюун санааг гэрэлтүүлж өгснийг зөв зүйтэй тэмдэглэжээ.

В. И. Лениний бодит дүр анх удаа дурсгал бичгийн болоод үндэсний үргэлжилсэн үгийн зохиол, нийтлэлд дүрслэгдсэнээр шинэ Монголын уран зохиол дахь Лениний дүрийн судлалд үндсийн үндэс болов. Уг номын зохиогчийн нотолгоогоор, азтай тохиолдолоор дэлхийн коммунист ажилчны хөдөлгөөний их багштай учирч байсан гучаад хүнээс тун цөөн нь Лениний дүрийг бүтээх гэж оролдож байжээ. Монголын

нэрт хувьсгалч, нийгмийн зүтгэлтэн Балингийн Цэрэндорж (1868— 1928 он) В. И. Ленинтэй уулзсан тухай сонирхолтой тэмдэглэл үлдээсэн байдаг.¹ Тэрхүү тэмдэглэлийн зарим нэг хэсэг нь агуулгаараа Иркутск дахь Коминтерний Алс Дорнодын секторын төлөөлөгч Б.З. Шумяцкийн (1896—1943 он) энэхүү уулзалтын талаар бичсэн тэмдэглэлтэй ойролцоо юм.²

Лениний Монголын төлөөлөгчидтэй хийсэн олон удаагийн уулзалтанд В. З. Шумяцкий оролцож байсан болохоор түүний тэмдэглэл өргөн цар хүрээтэй.

Монголын үргэлжилсэн үгийн нэрт зохиолч, нийтлэлч, жүжгийн зохиолч, яруу найрагч, шүүмжлэгч С. Буяннэмэх 1922 онд Алс Дорнодын коммунист хувьсгалт намуудын анхдугаар хурлын ажиллагаанд оролцсон бөгөөд энэ үедээ тэрээр анх удаа Ленинийг харжээ. Хожим нь арван дөрвөн жилийн дараа «Мартагдашгүй уулзалт» хэмээх Лениний тухай шилдэг бүтээлүүдийнхээ нэгийг туурвин бүтээсэн билээ. С. Буяннэмэх үүнээс өмнө «Ленин» (зураглал), «Зөвлөлт-Монголын найрамдал», «Багш Ленинтэй миний уулзсан тухай» зэрэг хэд хэдэн зохиол нэлээд шүлэг, тэмдэглэл, мэдээллийг бичиж Лениний энгийн бөгөөд ухаалаг дүр төрхийг зураглан бодож боловсруулсан ажээ. Зохиогчийн үзэж байгаагаар бол с. Буяннэмэх В. И. Лениний дүр төрх, тэр үеийн санаа сэтгэл, оюун ухааныг үнэн зөвөөр дүрслэн харуулж чадсан байна.

С. Буяннэмэх, Лениний монголын төлөөлөгчидтэй уулзсан тухайн агшныг үгээр илэрхийлэн бичихдээ: «Ленин төлөөлөгч нарт туйлын товчхон маш гүн утгатай хариулт зөвлөлгөөг өгсөн бөгөөд утга бүрийг бодох санах тутам, хэдий товчхон ч ер цөөн хэмээн дутагдах зүйл байхгүй юмаа» гэж өгүүлээд найрууллын эцэст «Лениний сургаал суртал, Лениний ном зохиол олон бөгөөд түүн лүгээ манай монголын олон залуучууд улам улам гүнзгийгээр суралц. . .» гэж зөв зүйтэйгээр уриалан дууджээ. Зохиолч хожим нь марксизм-ленинизмийг монголд дэлгэрүүлэх үйлст чадлын хэрээр хувь нэмэр оруулж залуучуудын хэвлэлд марксист сургаалын түүхээр хэд хэдэн өгүүлэл нийтлүүлсэн юм.³

Б. Өлзийсүрэн, С. Буяннэмэхийн «Мартагдашгүй уулзалт» найруулал нь зохиолчын нийтлэлийн болоод уран сайхны авъяас билэг, үзэл санаа-гоо зүйн болоод ертөнцийг үзэх үзлийн оргил болж, монголын үргэлжилсэн үгийн зохиол, үндэсний утга зохиол дахь Лениний дүрийн судлалын эхлэлд гүн гүнзгий ул мөрөө үлдээсэн юм гэж зөв тэмдэглэжээ.

Зохиогчийн үзэж байгаагаар, Лениний дүрийг бүтээн туурвисан зохиолч маань уран зохиолын хойч үеийнхэндээ ч цог бадрангуй үлгэр дууриалыг үлдээжээ. Мөн С. Буяннэмэх шинэ монголын уран зохиолд аугаа их Лениний амьдралын зурвасхан агшныг, түүнтэй уулзсан өөрийн завшаантай бөгөөд давтагдашгүй учралаас үүссэн хувийн сэтгэгдэл дээр үндэслэн тодорхойлон дүрсэлжээ. С. Буяннэмэхийн гавъяа нь энэхүү уулзалтын сүр жавхлан, бүхий л ач холбогдлыг

1 Б.Цэрэндорж «Ленинтэй уулзсан тухай» В. И. Ленин. Монголын тухай номонд. Улаанбаатар 1960, 68 — 70 тал.

2 Б. Шумяцкий «Ленин, монголын хувьсгалын тухай» В. И. Ленин, Монголын тухай номонд. Улаанбаатар 1960, 71—75 тал,

3 С. Буяннэмэх. Марксын суртал. «Монгол Ардын Нам» 1929. № 17 57—288 тал.

ухамсарлан ойлгож, энэ уулзалтын талаар, Лениний тухай яруу тод хүүрнэн өгүүлсэнд оршино.

Зохиогч, В. И. Ленин, Д. Сүхбаатар нарын түүхэн уулзалтыг дүрслэн харуулсан зохиолчид лугаа уншигчдын анхаарлыг зүй ёсоор хандуулжээ. Энэхүү уулзалт нь монголын ард түмний тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө хувьсгалт хөдөлгөөний эргэлтийн үе болсон юм. Уг дурсгалт уулзалтыг Ц. Гайтав (1929—1980), Ч. Лодойдамба (1916—1969 он), Д. Сэнгээ (1916—1959 он), Ч. Чимид (1927-1980 он), Л. Түдэв нар уран сайхны аргаар ерөнхийлөн дүгнэсэн ажээ. В.И. Ленин, Д. Сүхбаатар нарт зориулсан хэд хэдэн бүтээлийг уламжлалт туульсын хэлбэрээр бичсэн бөгөөд тухайлбал, Ч. Чимидийн «Сүхбаатарын сэлэм» (1942 он.г.м) зохиол нь бүрэн дүүрэн реалист аргаар дүрслэгдсэн юм. Сүүлийн үед үргэлжилсэн үгийн нэрт зохиолч Л. Түдэвийн түүх-улс төрийн сэдэвт «Алтан гадас» тууж, Ц. Гайтавын «Ленин бидэнтэй хамт», «Дамдины Сүхбаатар» зэрэг найрууллууд болон бусад олон зохиол бүтээл энэ сэдэвт хамаарагдаж байна.

Уран зохиолын дурсгал бичгийн түүхэн сурвалжуудаас, Монголын төлөөлөгчид В. И. Ленинтэй уулзахад оролцсон ахмад партизан А. Мягмарын дурдатгал дээр үндэслэн бичсэн Ч. Чимидийн «Нэгэн мартагдашгүй уулзалтын тухай» найраглал нэлээд үнэтэйд тооцогддог.

Б. Өлзийсүрэнгийн номын гол бүлгийн нэг бол «Монголын уран зохиол дахь Лениний дүрийн судлалын дүгнэлт ба сургамж, орчин үе» бүлэг билээ. Ленинд зориулсан зохиол бүтээлийн олонхи нь шүлэг, найраглалын хэлбэрээр бичигдсэнийг онцлон тэмдэглэе. Ер нь олон үндэстний утга зохиол дахь Лениний дүрийн судлалд яруу найраг зонхилдог. Иргэний, улс төрийн болоод цоглог утга уянга нь яруу найрагчдын, заримдаа ардын туульчдын санаа бодол, сэтгэгдэл, ертөнцийг үзэх үзлийг тодорхой, ойлгомжтойгоор илэрхийлж байдаг.

Монголын Лениний дүрийн судлал нь сэдвийн хувьд маш олон янз. Лениний тухай хэд хэдэн зохиол бүтээлд, баатруудын сэтгэлийн хөдлөл, тэдний ертөнцийг ойлгох ойлгоцоор дамжуулж Ленинийг дүрсэлжээ. Ийм зохиолуудад Д. Намдагийн «Эрхэм зураг», Ч. Чимидийн «Эхийн хайр», Н. Банзрагчийн «Талын гэрэл», Д. Мягмарын «Нууц дурсгал» зэрэг өгүүлүүд орно. Сүүлийн жилүүдийн зохиол бүтээл Лениний хувийн амьдрал, үйл ажиллагаатай шууд холбоотойгоор дүрслэгдэж буй нь баярлууштай. Тэдгээрт Монголын яруу найрагчдын Улаан талбайн тухай мөчлөг шүлгүүд болон Ж. Шагдарын «Енисей мөрний эрэг дээрх уулзалт», С. Дашдэндэвийн «Ленин ба хоньчин» зэрэг шүлгүүд хамаарагдана. Үүнээс гадна Монголын уран зохиолд Ильичийн «гэрэл»-д зориулагдсан багагүй зохиол бүтээл бий. Тэдгээр нь утга зохиол дахь Лениний дүрийн судлалыг баяжуулж, түүний олон талтайг харуулж байна. Номын төгсгөлийн хэсэгт зохиогч, Лениний тухай энэхүү шалгарсан зохиол бүтээлүүд нь монголын зохиолчдод аугаа их ур чадварын сургууль болсон бөгөөд болсоор ч байх болно. Сүүлийн хэдэн арван жилд БНМАУ-д уран сайхны орчуулгыг өргөн хэмжээнд хүлээн авдаг болсны ачаар монголчууд түүнийг (Лениний тухай зохиол бүтээлийг) төрөлх хэл дээрээ уншдаг боллоо гэсэн дүгнэлтийг хийжээ.

Б. Өлзийсүрэн, зохиолчид аугаа их Лениний дүрийг бүтээх үеийн алдаа дутагдлын талаар тэмдэглэхдээ, В. И. Лениний тухай болоод хувьсгалын сэдвүүд нь ангийн шинж чанартай байна иймээс жолоодогчийн дүрийг дүрслэхдээ зарлан тунхагласан, худал хуурмагаар

гоёж чимсэн, хэтэрхий товойлгосон маягаар хандаж болохгүй, тэгвэл зохиол бүтээлийн үзэл санаа, агуулгыг илэрхий бууруулна хэмээн зөв зүйтэй бичжээ. В. И. Лениний тухай болоод хувьсгалын сэдвүүд нь түүх-хувьсгалын бадрангуй хөгжил, монголын утга зохиолын чиг хандлагатай нягт уялдаатай юм. Иймд зохиолчдоос гагцхүү түүх-хувьсгалын тухай сэдвийн хөгжил дэх улс төр, түүх, гоо сайхны танин мэдэхүйг гаргах төдийгүй түүх, хувьсгалын үнэн, уран сайхны итгэл үнэмшлийг мөнхийн харилцаанд нь чадварлагаар дүрслэн харуулахыг гүнзгий шаардаж байна. Энэхүү сэдвүүд нь үнэнхүү амин чухал зүйл бүлгээ. Зөвлөлтийн монголч эрдэмтэн Л. К. Герасимович, Н.О. Шарак шинова, К.Н. Яцковская нар зохиогчийг судалгаа хийх хүртэл монголын уран зохиол дахь Лениний дүрийн судлалын гол зангилаа асуудлуудыг боловсруулсан юм. БНМАУ-д В. И. Ленинд зориулсан эмхэтгэлүүд хэвлэгдэн гарч¹, утга зохиол судлаач Ш. Цэнд-Аюуш утга зохиол дахь В.И. Ленин, Д. Сүхбаатар нарын дүрд зориулсан судалгааны зохиолоо хэвлүүлжээ.² БНМАУ-д түүхийн утга зохиолын судлалыг улам бүр баяжуулж байгаа монголын утга зохиол дахь Лениний дүрийн судлалын хөгжлийн иймэрхүү замууд байна.

Оросоос орчуулсан **Ч. Эрдэнэбаяр**

**«БНХАУ ДАХЬ ҮНДЭСТНИЙ
ЗАРИМ АВТОНОМИТ РАЙОНЫ
БАЙДАЛ (1976—1983)»**

(Улаанбаатар - Прага 1987)
номын тухай танилцуулга

«БНХАУ дахь үндэстний зарим автономит районы өнөөгийн байдал (1976—1983) хэмээх нэгэн сэдэвт хамтын бүтээлийг БНМАУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэн, БНСЧСУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд хамтран бичив. Уг хамтын бүтээл нь БНХАУ-ын хятад биш үндэстнүүдийн талаар урьд өмнө бичиж хэвлүүлсэн судалгааны ном зохиолуудын үргэлжлэл болох юм.

Энэхүү номыг зохиогчид ХКН, Хятадын засгийн газраас үндэстний талаар явуулж ирсэн бодлого түүний мөн чанар, сүүлийн үед үндэстний бодлогод гарч буй зарим нэг өөрчлөлтийн асуудлыг БНХАУ-ын үндэстний 5 автономит районоос нэлээд томоохон нь болох, эрт дээр цагаас эхлэн манай улсын түүх, соёлын хөгжилтэй ямар нэг талаар холбоотой явж ирсэн Өвөрмонгол, Төвд, Синьцзян 3 районы улс төр, нийгэм-эдийн засаг, соёлын хөгжилтөөр харуулжээ.

Уг номын «Өвөрмонголын өөртөө засах орон» 1 хэсэгт, Өвөрмонгол нь БНХАУ-ын нэг автономит район болон зарлагдсан 1947

1 Ленин амьд бүхнээс амьд. Улаанбаатар, 1970, 253 тал Мөнх Ленин, Улаанбаатар, 1980, 150 тал
2 Утга зохиолд мөнхөжсөн Ленин, Сүхбаатар, Улаанбаатар 1977, 94 тал